| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,170,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,170,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,100,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,050,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 50,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,931,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,931,900.00 |

| | | |
|---|---|---|
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 9,201,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 9,201,900.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 9,201,900.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

*Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь бүрэн дунд боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага.

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2022 онд “Хүүхэд бүрийн сурах үйлийг дэмжиж, сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний хөгжил, төлөвшил, сурлагын амжилт, чанарын ахиц гаргах багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, хяналт тавих
- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах
- Мэдлэг чадвараа дээшлүүлэх
- Эрүүл аюулгүй орчинд суралцах нөхцөл бүрдүүлэх

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

*Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа дараах хууль журмыг ашигладаг байна. Үүнд:

- ❖ Боловсролын тухай хууль
- ❖ Бага дунд боловсролын тухай хууль
- ❖ Төрийн албаны тухай хууль
- ❖ Төсвийн тухай хууль
- ❖ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ❖ Шилэн дансны тухай хууль
- ❖ Төрийн хэмнэлтийн тухай хууль
- ❖ Татварын тухай хууль гэх мэт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах *шаардлагагүй* гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

*Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар*

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, батлаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 446.7 сая төгрөгөөр буюу 11.7 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 30,804.7 | 30,804.7 |
| Авлага | 4,599.9 | 1,530.0 | (3,069.9) |
| Бараа материал | 114,735.3 | 153,255.1 | 38,519.8 |
| Үндсэн хөрөнгө | 3,705,863.6 | 4,086,311.9 | 380,448.3 |
| **Нийт хөрөнгө** | **3,825,198.8** | **4,271,901.7** | **446,702.9** |
| Өр төлбөр | 573.4 | 11,005.9 | 10,432.5 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 3,824,625.4 | 4,260,895.8 | 436,270.4 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **3,825,198.8** | **4,271,901.7** | **446,702.9** |

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оноос мөнгөн хөрөнгө 30.8 сая төгрөгөөр, бараа материалын данс 38.5 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийн данс 380.4 сая төгрөгөөр, өр төлбөрийн дансны үлдэгдэл 10.4 сая төгрөгөөр, Засгийн газрын хувь оролцоо данс 436.3 сая төгрөгөөр тус тус өсөж, авлагын дансны үлдэгдэл 3.1 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант оны эцэст улсын төсвөөс 30.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан ба цалингийн зардлын батлагдсан төсвөөс 27.6 сая төгрөгийн, бараа үйлчилгээний бусад зардлын төсвөөс 3.2 сая төгрөгийн үдэгдэлтэй байна.

Авлагын данс оны эхэнд 4.6 сая төгрөгийн гэрэл цахилгааны авлагын үлдэгдэлтэй бөгөөд өмнөх оны үлдэгдлийг бүрэн барагдуулж оны эцэст шуудан холбооны 1.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гарсан байна.

Оны эхэнд бараа материалын данс 114.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба төсвийн хөрөнгөөр нийт 236.3 сая төгрөгийн бараа материал худалдан авч 190.9 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулжээ.

Мэргэжлийн хяналтын газраас хоол, хүнсний аюулгүй байдлыг хангах, үүсэж болзошгүй эрсдэлийг хангах чиглэлээр сургууль, дотуур байрны хүнсний агуулахад хадгалагдаж байгаа махны чанар, хадгалалтын горим, хэрэглэж дуусах хугацаа, ариун цэврийн байдалд хяналт шалгалт хийхэд тус сургуулийн агуулахад байгаа 1161 кг мах муудаж хүнсэнд хэрэглэх боломгүй байгааг тогтоосон байна.

Үүний дагуу 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн муудсан махыг устгаж зөрчлийг арилгуулах 40-02-163/01 тоот албан шаардлага хүргүүлсний дагуу сургуулийн захирлын А/27 тоот тушаалаар байгуулагдсан устгалын комисс 3.5 сая төгрөгийн махыг устгаж, данс бүртгэлээс хассан байна.

Мөн тус сургуулийн бусад хангамжийн материал дансанд 2006 оноос  бүртгэлтэй байгаа жилийн эцсийн хөрөнгөөр тоолох боломжгүй болсон 3.3 сая төгрөгийн хөрөнгийн А/56 дугаар тушаалаар акталж данс бүртгэлээс хассан байна.

Үндсэн хөрөнгийн данс оны эхэнд 4080.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба төсвийн хөрөнгөөр 60.0 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч 412.2 сая төгрөгийн дансны үнэтэй хөрөнгийг үнэгүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Үүнд 365.5 сая төгрөгөөр сургуулийн байрны их засвар, 12.0 сая төгрөгийн мотор, 4.0 сая төгрөгийн хөлдөөгчийн сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр, 20.5 сая төгрөгийн үдийн хоолны тоног төхөөрөмж, 13.7 сая төгрөгийн сурагчийн парт, ширээ сандал, 5.4 сая төгрөгийн номыг БСШУЯ-наас үнэгүй хүлээн авчээ.

Оны эцэст нийгмийн даатгалын шимтгэлд төлөх 11.0 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4260.9 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 436.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1457.0 сая, нийт зарлагыг 1457.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 91.0 зардлыг сая төгрөгөөр бууруулж 1366.0 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 467.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1833.0 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1898.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 286.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1898.1 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 283.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2151.0 сая төгрөг буюу 98.4 хувьтай байгаа нь орон нутгаас авсан төсвөөс 2.8 сая төгрөгийг төвлөрүүлж, улсын төсвөөс 30.8 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэл үлдсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80112-нийтлэг үйлчилгээ | 286,548.5 | 283,715.1 | (2,833.4) | 99.0 |
| 2 | 80226- байр ашиглалтын үйлчилгээ | 4,350.3 | 4,350.3 | - | 100.0 |
| 3 | 80312-сургалт семинар | 2,175.2 | 2,175.2 | - | 100.0 |
| 4 | 80601-эрүүл мэндийн үйлчилгээ | 5,002.9 | 4,474.6 | (528.3) | 89.4 |
| 5 | 81801-үдийн цайны хөтөлбөр | 78,855.9 | 78,855.9 | - | 100.0 |
| 6 | 81806-дотуур байрны үйлчилгээ | 194,357.5 | 194,357.5 | - | 100.0 |
| 7 | 81816-хүүхэд ээлтэй сургалтын орчин | 59,940.0 | 59,725.0 | (215.0) | 99.6 |
| 8 | 81823-боловёролын байгууллагын багш | 9,788.2 | 7,314.0 | (2,474.2) | 74.7 |
| 9 | 81834-боловёрлын стандарт сургалт | 1,339,249.1 | 1,311,931.9 | (27,317.2) | 98.0 |
| 10 | 81835-сургалтын хэвийн үйл ажиллагаа | 204,386.4 | 204,116.4 | (270.0) | 99.9 |
| | **Дүн** | **2,184,654.0** | **2,151,015.9** | **(33,638.1)** | **98.4** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

БСШУЯ-наас 9.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт ирснийг 1.2 сая төгрөгийг цалингийн зардалд, 4.0 сая төгрөгийг шатахууны зардалд, 3.9 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

# 4. АУДИТЫН ТАЙЛАН

## 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1797.5 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 17.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх үе шатанд материаллаг байдлыг Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 2606.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 26.1 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

Тус 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого өмнөх оноос 808.6 сая төгрөгөөр нэмэгдсэн тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоох нь зүйтэй гэж үзсэн.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор үндсэн үйл ажиллагааны орлогыг төвлөрүүлж ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах алдаа, зөрчил илэрч албан шаардлага өгсөн. Үүнд:

Оны эцэст цалингийн зардлын төсвөөс 24.0 сая төгрөгийг хэмнэж улсын төсвийн санхүүжилтээс 30.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан боловч тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс 11.0 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгтэй гарсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д “хуваарьт болон хугацаа

хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх” гэсэн заалтыг зөрчжээ.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад 6 дугаар зүйлийн 6.4.8, 6.8.1 дэх заалтыг зөрчиж 8.8 сая төгрөгийн мөнгө зарцуулсан 8 тушаал шийдвэрийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна. Мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75 хувьтай байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар алдаа зөрчил илрээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,986.9 сая төгрөгийн зөрчил илэрч 20.6 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 1,964.9 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 1.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон. Үүнд:

Дотуур байрны хүүхдийн нэг өдрийн хоолны зардлын нормыг хэтрүүлэн зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан.

Жилийн эцсийн эд хөрөнгийн үлдэгдлийн тооллого хийгдээгүй, нягтлан бодогч нь тооллогын дүнгээр хөрөнгийн тооцоо бодсон акт үйлдэж, хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст оруулбал зохих 149 мэдээллээс 41 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн бөгөөд албан шардлагын хэрэгжилт 99.5 хувьтай байна.

*Хүснэгт 4* Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 1.4 | 1 | 1.4 | 100% |
| Албан шаардлага | 2 | 1964.9 | 2 | 1955.2 | 99.5% |
| Зөвлөмж | 0 | 0 | | | 0% |
| Нийт дүн | 3 | 1966.3 | 3 | 1956.6 | 99.7% |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах зүйл гараагүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд нийт 633.5 сая төгрөгийн залруулга хийгдсэн болно. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайлангийн баланс дахь бусад биет бус хөрөнгө болон өмнөх үеийн хуримлагдсан үр дүнгийн эхний үлдэгдлийг 93.2 сая төгрөгөөр зөрүүтэй ирүүлснийг залруулав.

2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлогын дүнг 59.7 сая төгрөгөөр буюу төсвийн хөрөнгөөр худалдаж авсан үндсэн хөрөнгийн дүнг нэмж бүртгэж ирүүлснийг залруулав.

3. Үнэ төлбөргүй гарсан зардлын 6.8 сая төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд бүртгээгүй байсныг залруулав.

4. Мөнгөн гүйлгээний тайланд 60.0 сая төгрөгийн биет ба биет бус хөрөнгө худалдан авсан гүйлгээг үйл ажиллагааны зардал оруулан тайлагнасныг залруулав.

5. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөг 393.8 сая төгрөгөөр дутуу, төсвийн гүйцэтгэлийн орлогыг 12.0 сая төгрөгөөр, зарлагыг 8.0 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнаж ирүүлснийг залруулав.

Аудитаар нийт 26.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 26.6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй болно.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримттай холбоотой асуудал***

*1.1. Илрүүлэлт:* Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй, сургуулийн удирдлага болон нягтлан бодогч нь санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар

ойлголт, мэдээлэлгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д “"нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг”, 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.” гэснийг зөрчсөн ба АОУС-250-д "Санхүүгийн тайланд хууль тогтоомж, дүрэм, журмыг анхаарах", УСНББОУС-1, MNS 6817-4:2020 стандартууд болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*1.2 Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийн хангаж нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж санхүү, бүртгэл, тайлагналын үйл ажиллагаандаа ашиглах, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нар санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар мэдээлэл авч, ойлголттой болох;

***2. Байгууллагын эзэмшлийн газартай холбоотой асуудал***

*2.1.Илрүүлэлт:*

Алтай сумын Засаг даргын 2016 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 58 тоот захирамжийг үндэслэж Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр 08304-2019/00006 дугаар гэрээгээр 40212 м/кв газрыг 30 жилийн хугацаатай эзэмшүүлэх гэрээ хийсэн боловч данс бүртгэлд үнэлж тусгаагүй байна.

*2.2. Өгсөн зөвлөмж:* Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д ”Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.8-д “Газар эзэмших гэрээ нь эрхийн гэрчилгээний хамт хүчин төгөлдөр байх бөгөөд гэрээний биелэлтийг талууд жил бүр дүгнэнэ” гэсэн заалтуудыг баримталж дээрх боловсролын байгууллагын эзэмших зориулалтаар авсан 3407 мкв буюу 6.8 сая төгрөгийн газар эзэмших эрхийг үнэлж, данс бүртгэлд тусгах.

***3. Бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

*3.1.Илрүүлэлт:*

Оны эцэст цалингийн зардлын төсвөөс 24.0 сая төгрөгийг хэмнэж улсын төсвийн санхүүжилтээс 30.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан боловч тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс 11.0 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгтэй гарсан.

3*.2.Өгсөн зөвлөмж:*

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “ Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5-д “ дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлж санхүүгийн тайлан гаргахаас өмнө өр, авлагын тооцоог баталгаажуулах, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг барагдуулах.

***4. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

*4.1.Илрүүлэлт:*

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад 8.8 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан 8 тушаал шийдвэрийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй, мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75 хувьтай байна.

*4.2. Өгсөн зөвлөмж:* Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг баримталж шилэн дансны нэгдсэн мэдээллийн цахим хуудаст төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрээ хугацаандаа бүрэн байршуулж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланд зөрүүтэй тайлагнасан алдааг залруулав | 5 | 633517.5 | | | 5 | 633517.5 | 5 | 633517.5 | | | | |
| Дүн | 5 | 633517.5 | | | 5 | 633517.5 | 5 | 633517.5 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй | 1 | | | | | | 1 | | | | | |
| Байгууллагын эзэмших газрыг данс бүртгэлд тусгаагүй байна | 1 | 6814.0 | | | | | 1 | 6814.0 | | | | |
| Дүн | 2 | 6814.0 | | | | | 2 | 6814.0 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тайлант онд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 8 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй байна | 1 | 8806.5 | | | | | 1 | 8806.5 |
| **Дүн** | **1** | **8806.5** | | | | | **1** | **8806.5** |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| НДШ-д өглөгтэй гарсан | 1 | 11005.9 | | | | | 1 | 11005.9 |
| | | | | | | | | |
| Дүн | 1 | 11005.9 | | | | | 1 | 11005.9 |
| **Нийт дүн** | **2** | **19812.4** | | | | | **2** | **19812.4** |